



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№253 /462/

2023.01.25

## Цаг үе, үйл явдал

# Г.САЙХАНБАЯР: СТРАТЕГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОРОЛЦОО НЭМЭГДСЭЭР БАЙНА

Монгол Улсын дэд бүтцийн бүтээн байгуулалт, тэр дундаа төмөр замуудын барилга угсралтын их бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний оролцооны талаар Mining Insight сэтгүүлийн сэтгүүлч Б.Энхмаатай ярилцсаныг хүргэж байна.

**Барилгын цэргийн ангиар тодорхой мэргэжил, ур чадварыг эзэмшүүлж, улс орны бүтээн байгуулалтыг босголцож ирсэн түүхээс ярилцлагаа эхэлье.**

- Монгол Улсын Зэвсэгт хүчин 100 гаруй жилийн түүхэн хугацаандаа эх орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах үндсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ улс орныхоо бүтээн байгуулалтад гар бие оролцон өнөөгийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулсаар ирсэн түүхтэй. 1936 онд тухайн үеийн Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмидийн санаачилгаар “Барилгын цэрэг”-ийг анх байгуулж, нийслэл Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Чойбалсан хот болоод аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, орон нутгийн их бүтээн байгуулалтуудад оролцож, Монголын барилгын салбарт болоод улс орны хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэсэн. 2005 онд “Барилгын цэрэг”-ийг татан буулгаж, Зэвсэгт хүчний бүтцэд 1 анги, 1 салбар л үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байлаа. Үүнээс 10 жилийн хойно батлан хамгаалахын эрх зүйн орчныг сайжруулах асуудалд төр засаг, батлан хамгаалахын удирдлагын зүгээс онцгойлон анхаарч, төрөөс баримтлах бодлого, түүнийг дагалдан гарах хуулиудыг шинэчлэн баталж, мөрдөж эхэлсэн юм. 2019 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд бүтээн байгуулалтын асуудал хариуцсан нэгж бий болсон. Жилийн дараа Зэвсэгт хүчний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Барилга-инженерийн цэргийн удирдах газрыг байгуулах түүхэн шийдвэр гарсан. Энэ нь маш зөв бодлого болж, богино хугацаанд бодит биеллээ олсныг улс орны өнөөгийн бүтээн байгуулалтын томоохон ажлууд оролцоо, үр дүн харуулж байна. Батлан хамгаалах яамнаас онцгойлон анхаарснаар Барилга-инженерийн цэргийн удирдах газрын харьяа ангиудын хүний нөөцийн чадавч, удирдлага, зохион байгуулалт, техник, тоног төхөөрөмжийн хангалт эрс дээшилсэн. Барилга-инженерийн цэргийн улсыг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалт дахь оролцоо жилээс жилд нэмэгдэж байна. Төр засгаас даалгасан үүргийг өндөр хариуцлага, нэгдсэн зохион байгуулалттайгаар, богино хугацаанд, өндөр түвшинд гүйцэтгэж байна.

Сүүлийн жилүүдэд төмөр замуудын барилгын ажил эрчимжиж Зэвсэгт хүчний оролцоотой хэрэгжиж байна. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад хэчнээн анги нэгтгэл ямар төрлийн ажлуудыг гүйцэтгэсэн бэ?

- Дорноговь аймгийн нутгаар үргэлжлэн БНХАУ-ын Мандал боомттой холбох экспортын төмөр замын ажилд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн 6



ангийн 1000 гаруй алба хаагч, 400 гаруй нэгж техниктэйгээр 2022 оны 02 дугаар сараас эхлэн оролцсон. Бүтээн байгуулалтын хүрээнд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн төмөр замын трассын дагуу 4,6 орчим сая шоо метр газар шорооны ажил, 63 байрлалд ус өнгөрүүлэх хоолой, 35 орчим км дээд бүтэц тавих ажлыг хагас жил гаруй хугацаанд чанар, стандартын дагуу бүрэн гүйцэтгэж, хүлээлгэн өгөөд байна. Тухайлбал, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаас Ханги чиглэлд салаалсан төмөр замын эхлэл хэсэг болох 3 замын уулзвар нь нэлээд түвэгтэй, нарийн тооцоолол шаардсан маш том ажил байсан. Энэхүү өндөр хурдны 1/11 маркийн суман шилжүүлэг бүхий 1200 м-ийн радиустай, 80 м өргөн, 5.9 км урт, 11 салаа бүхий тойрог төмөр замыг манай инженер техникийн ажилчид барьсан. Үүний зэрэгцээ төмөр замын 3 хос гүүрийг 9 байршилд байгууллаа.

### Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын онцлог, эдийн засгийн давуу талыг Та хэрхэн харж байна вэ?

- Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-оор төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөсөн. “Боомтын сэргэлт”-ээр хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбож, тээвэр, ложистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, ачаа тээврийн урсгалыг сайжруулах зорилготой. Цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлж, боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлнэ. Энэ дагуу хэрэгжсэн Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор Дархан, Сэлэнгийн бүсээс Замын-Үүд-Эрээн-Жинин-Хөх хот-Бугат (1,722 км) чиглэлийн тээврийн маршрут Сайншанд-Зүүнбаян-Ханги-Мандал-Бугат (1,404 км) чиглэлд 318 км дөт болох давуу талтай. Ингэснээр уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртөг буурахаас гадна манай улсын импорт, экспортын бараа бүтээгдэхүүний нэвтрэх хүчин чадал нийт 20 сая тонноор, төмөр замаар тээвэрлэгдэж байгаа нийт тээврийн хэмжээ 65 хувиар тус тус нэмэгдэх боломжтой болно гэсэн тооцоолол гарснаас ач холбогдлыг тодорхойлж болно.

### Зэвсэгт хүчин бүтээн байгуулалтын чамгүй хэдэн төслийн ард гарлаа. Бусад ажлуудын талаар дурдвал?

- Улс орны стратегийн бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний алба хаагчдын оруулсан хувь нэмэр асар их. Тухайлбал, “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн 17.5 км хүнд даацын автозам, үйлдвэрийн ажилчдын 5 блок барилгын ажил, Дорнод аймгийн Халх гол суманд хэрэгжсэн “Шинэ сум” төслийн ажил, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын ажил, Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км төмөр замын бүтээн байгуулалт, Дарханы авто замын ажил зэргийг дурдаж болно. Эдгээр бүтээн байгуулалтын ажлыг Монгол Улсын Зэвсэгт хүчин, дотоодын аж ахуй нэгж, байгууллагуудын хүчээр нийт 310 орчим тэрбум төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэсэн нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниар гүйцэтгүүлэхээс даруй 2.5 дахин бага зардлаар хийсэн юм. Барилга-инженерийн цэргийн хувьд урьд нь төмөр зам барих туршлага байгаагүй ч хамтран ажилласан байгууллагууд, инженер, техникийн ажилчидтай хамтарсан сургалт, дадлагуудыг цаг тухайд нь зохион байгуулж, бие бүрэлдэхүүний мэдлэг, чадварыг дээшлүүлсний үр дүнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж 2021 онд хүлээлгэн өгсөн. Уг төсөлд Барилга-инженерийн цэргийн 9 ангийн 2200 гаруй алба хаагч, 600 орчим нэгж техниктэй оролцлоо. Доод бүтцийн шороон далан, дээд бүтцийн төмөр замыг тавьснаас гадна төмөр бетон ус өнгөрүүлэх хоолой, гүүр, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлыг 2,4 жилийн хугацаанд гүйцэтгэсэн. Энэ бол Барилга-инженерийн цэргийн алба хаагчдын хувьд том амжилт, бас туршлага. Барилга-инженерийн төрлийн цэргийн үүрэг гүйцэтгэх чадавч, хүчин чадал дээшилж, мэргэжлийн боловсон хүчний хувьд “эрийн цээнд” хүрч, бэхжиж байна.

### Цаашид Монгол Улсын Зэвсэгт хүчин ямар томоохон төсөлд оролцох бол?

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөл, Засгийн

газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчин Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын ажлаа дуусгаад шууд “Богдхан” төмөр замын төслийн доод бүтцийн ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр оролцож, ажлаа эхлээд байна. Уг төслийн эхний ээлжинд Барилга-инженерийн цэргийн ангиуд 37.5 км төмөр замын трассын далангийн газар шорооны ажил, 43 байрлалд, ус өнгөрүүлэх хоолой, 5 байрлалд гүүр, 3 зөрлөгийн бүтээн байгуулалтыг туслан гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэнэ. Ойрын хугацаанд Архангай, Говь-Алтай аймгууд дахь Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн ангийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, анги салбаруудаа төмөр зам, авто зам, үйлдвэр станцын барилга байгууламж барих зэрэг улсыг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажлууд болон орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц ажлуудад оролцуулах бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна.

### Томоохон бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн, чадварлаг бүрэлдэхүүн шаардлагатай. Тэгвэл мэргэжлийн бүрэлдэхүүнээ хэрхэн бэлтгэж, мэргэшүүлж байна вэ?

- Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчнийхээ боловсон хүчний нөөцийг бүхий л мэргэжлийн чиглэлээр харилцаа, хамтын ажиллагаатай гадаад орнууд, үндэсний их, дээд сургууль, бусад байгууллагатай хамтран бэлтгэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. Тэр дундаа бүтээн байгуулалтад оролдох мэргэжлийн хүмүүсээ бэлтгэхэд ихээхэн анхаарал хандуулдаг. Дотооддоо Үндэсний батлан хамгаалахын их сургуульд инженерийн болон барилгын мэргэжлийн офицер, ахлагч нарыг бэлтгэж, 2015 оноос эхлэн төмөр замын бүтээн байгуулалтад оролцох бэлтгэл ажлын хүрээнд зарим мэргэжлээр мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалт, техникийн мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх, аймаг, нийслэлийн МСҮТ-үүдтэй хамтран “Машин, механизмын оператор”-ын сургалтад хугацаат болон цэргийн гэрээт алба хаагчдыг хамруулан сургаж байна. Мөн цэргийн албанд орж ажиллах сонирхолтой 18-35 насны хэрэгцээтэй мэргэжилтэй залуусыг офицер, ахлагчийн албанд гэрээгээр элсүүлэн ажиллуулж байна. Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр Япон Улсын өөрийгөө хамгаалах хүчний Инженерийн цэрэгтэй хамтарч “Зам” нэртэй онол, дадлага хосолсон сургалт, дадлагыг жил бүр зохион байгуулж, авто зам, замын далан, үерийн ус зайлуулах байгууламж барих зэрэгт Барилга-инженерийн цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлж байна.

Ярилцсанд баярлалаа.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
-15	-31

ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
40	24

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,486	3,492
EUR	3,816	3,830
CNY	513.80	515
RUB	49.50	50
JPY	27	27.30
KRW	2.84	2.85

## ЗУРХАЙ



2023.01.25 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

**ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР**  
**ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

### Үс засуулбал:

**Бие эрхтний хүч сайжирна**  
**Наран ургах, шингэх:**  
**08.29-17.40**  
**Барилдлага:**  
Үхэх  
**Шүтэн барилдлага:**  
Нэр өнгө

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 622,545,290

Эдгэрсэн

Нийт: 602,361,215

Нас барсан

Нийт: 6,547,708

## МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН БАГ БҮРЭН БҮРЭЛДЭХҮҮНЭЭРЭЭ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЭХЭЛЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн баг таван удаагийн нислэгээр ажиллагааны газар оронд шилжин байрласан бөгөөд тав дахь цуврааны цэргийн алба хаагчид 01 дүгээр сарын 20-ны өдөр үүрэг гүйцэтгэх ажиллагааны газар орондоо ирсэн юм Энэ удаа дээрх бүрэлдэхүүнийг цэргийн багийн захирагчийн сургалт, соёл хүмүүжил эрхэлсэн орлогч дэд хурандаа П.Энхтайван ахалж ирснээр цэргийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллагааны газар оронд үүргээ гүйцэтгэж эхэллээ.

Цэргийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ үүрэг

гүйцэтгэж эхэлсэнтэй холбогдуулан цэргийн багийн захирагч хурандаа Н.Эрдэнэбаяр үүрэг чиглэл өгсөн бөгөөд хэлсэн үгэндээ "Бид бүхэн Эх орон, төр, ард түмнээ төлөөлөн Зэвсэгт хүчнийхээ өмнө хүлээсэн хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг залгамжлан мөн өмнөх ээлжийн цэргийн багийн нийт бие бүрэлдэхүүний ололт амжилтыг улам бататгаж хүн нэг бүр дор бүрнээ хичээж, үндсэн үүргээ гүйцэтгэхээс гадна бид бүхэнд амралт, чөлөөт цагаараа хувь хүний хөгжил, цэргийн хэргийн мэдлэг, дадлагад ур чадвараа хөгжүүлэх боломжууд нээлттэй байгаа" хэмээн онцлон дурьдаж, бие бүрэлдэхүүний цаашдын үүрэг гүйцэтгэлтэд нь амжилт хүссэн юм.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

## ИБУИНХУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас болон Япон Улсаас Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе хурандаа (Тэнгисийн цэргийн ахмад) Колин Виллиамс, атташегийн туслах Николас Жастин нарыг 2023 оны 01 дүгээр сарын

24-ний өдөр хүлээн авч уулзлаа.

Уг уулзалтаар шинээр томологдсон Английн Батлан хамгаалахын атташегийн төлөөлөгч нартай танилцаж, цаашид хоёр орны цэргийн хамтын ажиллагаа, харилцааг улам хөгжүүлэх болон бусад арга хэмжээний талаар санал солилцсон юм.

Дэд хурандаа З.АЛТАНЗОРИГ



# ДУНДГОВЬ АЙМГААС ХОС ХОСООРОО ИРСЭН ИХЭР ЦЭРГҮҮД



"Монгол Улсын төлөө зүтгэе" буландаа энэ удаа Зэвсэгт хүчний 167 дугаар ангид хос хосоороо хугацаат цэргийн алба хааж байгаа Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумын харьяат ихэр байлдагч нарыг онцолж байна.

Дундговь аймгийн Өлзийт сумаас ирсэн ихрүүдийг Жигжидсүрэнгийн Отгонбаатар, Жигжидсүрэнгийн Отгонбаяр гэдэг. Эхээс тавуулаа. Хайрт ээж Нэргүйн Өлзийбат нь хөвгүүдийнхээ хамт нутагтаа, ах, эгч нар нь Улаанбаатар, Дундговь, Өмнөговь аймгуудад ажиллаж амьдардаг гэнэ. Ихрүүд цэргийн албанд хүсэл мөрөөдлөөрөө ирсэндээ талархаж, олон зүйлээс суралцаж байгааг ярилцлагын эхэнд

өгүүллээ. Байлдагч Ж.Отгонбаатар "Цэрэгт ирээд олон зүйлийг эргэцүүлж, амьдралынхаа зорилго төлөвлөгөөг ч бодож байна. Эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж ойлгохын зэрэгцээ нийгэмд хариуцлагатай иргэн хүн байх, ээжийгээ асарч энэрэх хайрын тухай ч бодлууд хөвөрч байна даа.

Миний ижий сумаасаа урагш "Дэл" хайрхан овооныхоо ойролцоо өвөлжиж байгаа. 14 хоног тутамдаа холбоонд орно. Ярих бүртээ л "Олонтойгоо эв найрамдалтай байж, дарга нарынхаа хэлж ярьсныг сайн сур. Бүтээлч бай. Дүүгээ харж хандаж яваарай" гэдэг юм. Ээж минь 2019 онд аймгийнхаа сайн малчин болсон ажилсаг эмэгтэй л дээ. Манайх бод, бог нийлсэн 1000 гаруй малтай. Ихэр

бид хөдөөгийн залуусын жишгээр дунд сургуулиа дүүргээд ээждээ тусалж, малчин болсон. Халагдаад ч буцаад нутагтаа очиж, малаа маллаж сайхан амьдарна" хэмээн бахархалтайгаар ярилаа.

Түүний дүү байлдагч Ж.Отгонбаярын хувьд "Анх цэрэгт ирэхэд онжавууд бид хоёрыг ялгагдаггүй байсан. Одоо бол дуу, хөдөлгөөн, зан ааш нь бүгд өөр гэдэг. Цэргийн албанаас бид хоёр олон сайхан найз нөхөдтэй болж, бахархал, омогшил дүүрэн цаг хугацааг өнгөрүүлж байгаадаа баяртай байна" гэлээ. Тэд салааны захирагч дэслэгч Д.Дашмягмар, салааны орлогч ахлагч Б.Сүхбаатар нарыг цэргүүдээ зааж сургахын төлөө бүхнээ зориулдаг, заримдаа аав шиг, ах шиг нь байдаг гэж магтаж байлаа.

Дараагийн ихэр байлдагч нар



бол Эрдэнэбатын Эрдэнэбаяр, Эрдэнэбатын Өсөхбаяр. Тэд Дундговь аймгийн Сайнцагаан сумаас татагдан ирсэн залуус. Эхээс наймуулаа. Дөрвөн эгч, хоёр ахтай, айлын отгон хөвгүүд. Аав Н.Эрдэнэбат, ээж Ч.Нарангэрэл нь өдгөө Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа тусгай салбарт ажилладаг бөгөөд ах нар нь цөмөөрөө хугацаат цэргийн алба хаасан эрчүүд гэнэ. Аав нь 1988 онд Зэвсэгт хүчний 150 дугаар ангид хугацаат цэргийн алба хааснаа хөвгүүддээ ярьж, эр хүн болж төрсний хувьд эх орондоо бүртгэлтэй цэрэг явахыг багаас нь захиж ирж. Аавынхаа захиасаар том хүү Э.Жанчив Хилийн цэргийн 0129 дүгээр ангид алба хааж, залгуулаад хоёр бага хүү нь ирээд байгаа нь энэ ажээ. Харин дунд хүү Э.Сандуйжав нь Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тусгай салбарт алба хаадаг, ахлагч цолтой байна.

Ихрүүд ярилцлагадаа онц буудагч болсноо тодотгож, мэргэн буугаа улаан туузаар чимсэндээ олзуурхаж буй нь илт. Тэд спортоор хичээллэдэг, анги дотооддоо зохион байгуулагддаг уралдаан тэмцээний тэргүүлэгчийн эгнээнд багтдаг байлдагч нар гэнэ. Ихрүүдээс цэргийн албаны тухай сэтгэгдлийг нь сонирхоход "Цэрэг хүн хэзээ ч нэр төрийн төлөө, бусдын хүндлэлийг хүлээх гэж, хариу нэхэж үүрэг гүйцэтгэдэггүй юм байна гэдгийг



бие, сэтгэлээрээ мэдэрсэн. Эх орныхоо төлөө амьдарч, эх орныхоо төлөө амьдардаг гэдэг нь үнэн юм байна. Тийм болохоор салааны захирагч, ахлагч Э.Бямбасүрэн, салаа орлогч, дэд ахлагч Х.Бархасбат нарын зааж сургасан бүхнийг сурч, урмыг нь хугалахгүй юмсан гэж хичээдэг" гэж хариулав.

Нийтлэлийн баатар болох байлдагч Ж.Отгонбаатар, Ж.Отгонбаяр болон Э.Эрдэнэбаяр, Э.Өсөхбаяр нар Дундговь аймгийн Сайнцагаан, Өлзийт суманд ажиллаж амьдарч байгаа аав, ээж, ахан дүүс, нутгийн зон олондоо "Хөвгүүд нь эр цэргийн албандаа тун сайн байгаа" хэмээн мэндчилгээ дэвшүүлснийг энэ завшаанд уламжилъя.

Ахмад Д.БОЛОР